



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425-р нээлттэй хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/12/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Говьсүмбэр аймаг

2023 он

Дарга тэргүүлэх аудитор:

Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govisumber@audit.gov.mn

Дорж-Орлох № *25*
танай _____ -ны № _____ -т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР 425-Р
НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ М.БАТБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425-р нээлттэй хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425-р нээлттэй хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

008020070

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргатай 2023 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 58 арга хэмжээг батлуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 84.0 хувьтай байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	197,355,004.12	229,872,424.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,040,103.48	23,399,397.51
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,040,103.48	23,399,397.51
31210	Төгрөг	14,040,103.48	23,399,397.51
31211	Төрийн сангийн харилцах	14,040,103.48	23,399,397.51
33	АВЛАГА	1,157,852.83	3,139,339.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,157,852.83	3,139,339.21
35	БАРАА МАТЕРИАЛ	182,157,047.81	203,333,687.89
35100	Түүхий эд материал	46,363,744.70	49,127,378.50
35110	Тусгай зориулалттай материал	44,258,324.30	46,584,300.30
35130	Эм боох материал	2,105,420.40	2,543,078.20
35400	Хангамжийн материал	65,193,303.11	80,456,309.39
35410	Бичиг хэргийн материал	495,126.00	72,000.00
35420	Аж ахуйн материал	49,736,895.63	57,959,454.38
35440	Түлш, шатах тослох материал	987,000.00	10,028,831.00
35450	Барилгын засварын материал	0.01	0.01
35460	Хүнсний материал	13,974,281.47	10,042,024.00
35470	Бусад хангамжийн материал	0	2,354,000.00
35600	Мал амьтад	70,600,000.00	73,750,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,893,397,477.42	2,660,857,847.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,893,397,477.42	2,660,857,847.99
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	2,683,670,331.26	2,451,844,130.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,961,270,724.50	2,961,270,724.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-656,863,121.23	-800,076,785.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	264,083,633.00	155,583,633.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-144,929,907.48	-61,051,346.44
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	530,014,187.38	544,500,413.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-302,181,380.14	-376,655,883.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,672,654.00	61,672,654.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,067,860.77	-53,070,680.96
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	19,773,292.12	19,773,292.12
39212	Хуримтлагдсан элэгдэл	-101,890.12	-101,890.12
39300	Биет бус хөрөнгө	209,727,146.16	209,013,717.00
39301	Програм хангамж	3,567,146.16	3,567,146.16
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	-713,429.16
39303	Бусад биет бус хөрөнгө	206,160,000.00	206,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,090,752,481.54	2,890,730,272.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,374,121.53	14,389,915.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,374,121.53	14,389,915.56
41300	Өглөг	10,374,121.53	14,389,915.56
41360	Бусад өглөг	10,374,121.53	14,389,915.56
41361	Байгууллагад төлөх өглөг	0	5,951,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	10,374,121.53	8,438,415.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,080,378,360.01	2,876,340,357.04
51	Засгийн газрын хувь оролцоо	3,080,378,360.01	2,876,340,357.04
51100	Засгийн газрын оруулсан капитал	467,792,157.00	467,792,157.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	467,792,157.00	467,792,157.00

51200	Хуримтлагдсан үр дүн	211,741,772.61	7,703,769.64
51210	Өмнөх үеийн үр дүн	236,299,481.69	211,741,772.61
51220	Тайлант үеийн үр дүн	-24,557,709.08	-204,038,002.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,400,844,430.40	2,400,844,430.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,090,752,481.54	2,890,730,272.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,766,196,509.47	2,274,787,340.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	310,107,309.47	133,174,540.90
120	Нийтлэг татварын бус орлого	310,107,309.47	133,174,540.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	97,505,644.76	99,446,305.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,397,778.80	63,609,842.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	52,107,865.96	35,836,463.00
120009	Бусад орлого	70,000.00	105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	138,520,987.40	7,962,226.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	74,010,677.31	25,661,009.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,456,089,200.00	2,141,612,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,420,775,200.00	2,121,612,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,420,775,200.00	2,121,612,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,314,000.00	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,314,000.00	20,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,790,601,593.34	2,478,825,343.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,790,601,593.34	2,478,825,343.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,765,362,545.18	2,348,590,325.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	969,711,928.50	1,546,228,980.51
210101	Үндсэн цалин	614,728,047.76	945,796,741.19
210102	Нэмэгдэл	309,710,845.74	521,437,201.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,547,000.00	26,940,000.00
210104	Урамшуулал	31,726,035.00	51,255,037.71
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,359,627.46	30,643,751.04
210201	Тэтгэврийн даатгал	1,012,685.09	1,624,509.17
210202	Тэтгэмжийн даатгал	112,951.54	191,118.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,939.43	122,094.97
210204	Ажилгүйдлийн даатгал	6,187.89	30,523.75
210205	Эрүүл мэндийн даатгал	19,196,863.51	28,675,504.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	169,612,500.00	197,564,496.61
210301	Гэрэл, цахилгаан	86,142,909.53	115,270,866.35
210302	Түлш, халаалт	76,049,730.47	79,965,630.26
210303	Цэвэр, бохир ус	7,419,860.00	2,328,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,017,404.00	47,741,106.08
210401	Бичиг хэрэг	7,650,100.00	4,702,926.00
210402	Тээвэр, шатахуун	35,932,981.00	33,864,332.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,157,000.00	3,276,748.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,100.00	27,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,496,000.00	1,400,000.00
210408	Бараа материал акталсны зардал	20,754,223.00	4,470,000.00
2105	Нормативт зардал	222,260,371.55	224,114,382.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,289,348.50	4,844,120.10
210502	Хоол, хүнс	202,625,042.95	190,100,137.47

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,345,980.10	29,170,124.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,961,828.00	35,213,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	176,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	256,900.00	158,400.00
210604	Урсгал засвар	45,704,928.00	34,879,450.00
2107	Томилолт, зочны зардал	192,000.00	416,000.00
210702	Дотоод албан томилолт	192,000.00	416,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,105,400.00	11,496,553.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,545,300.00	5,336,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	398,800.00	160,546.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500.00	5,316,500.00
210807	Газрын төлбөр	1,441,800.00	617,157.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	260,141,485.67	255,171,205.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,741,650.00	7,767,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	378,100.00	378,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	239,021,735.67	247,025,855.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,239,048.16	130,235,018.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	99,739,499.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	96,714,499.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	3,025,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	139,048.16	1,769,197.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	139,048.16	1,769,197.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,000,000.00	28,726,322.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,000,000.00	28,726,322.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-24,405,083.87	-204,038,002.97
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	152,625.21	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	152,625.21	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-24,557,709.08	-204,038,002.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,592,097,657.88	2,257,603,211.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,008,457.88	115,990,411.60
120	Нийтлэг татварын бус орлого	136,008,457.88	115,990,411.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133,918,990.50	101,990,411.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	133,918,990.50	101,990,411.60
120009	Бусад орлого	2,089,467.38	14,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,456,089,200.00	2,141,612,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,420,775,200.00	2,121,612,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,420,775,200.00	2,121,612,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,314,000.00	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,314,000.00	20,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,546,174,870.49	2,241,719,917.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,546,174,870.49	2,241,719,917.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,520,935,822.33	2,111,484,899.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	965,552,500.00	1,557,924,873.92
210101	Үндсэн цалин	601,246,322.88	927,476,045.35
210102	Нэмэгдэл	319,033,142.12	548,092,032.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,547,000.00	30,060,000.00
210104	Урамшуулал	31,726,035.00	51,496,796.25
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,852,151.84	34,927,344.01
210201	Тэтгэврийн даатгал	214,200.00	93,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	25,200.00	11,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,612,751.84	34,822,844.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	169,612,500.00	207,564,496.61
210301	Гэрэл, цахилгаан	86,142,909.53	115,270,866.35
210302	Түлш, халаалт	76,049,730.47	89,965,630.26
210303	Цэвэр, бохир ус	7,419,860.00	2,328,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,262,200.00	40,751,348.08
210401	Бичиг хэрэг	7,650,100.00	3,854,800.00
210402	Тээвэр, шатахуун	35,932,000.00	32,532,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,157,000.00	2,937,448.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,100.00	27,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,496,000.00	1,400,000.00
2105	Нормативт зардал	150,747,800.00	170,900,357.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,496,000.00	5,499,777.90
210502	Хоол, хүнс	145,251,800.00	165,400,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,695,600.00	36,013,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	976,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	256,900.00	756,900.00
210604	Урсгал засвар	43,438,700.00	34,280,950.00
2107	Томилолт, зочны зардал	192,000.00	416,000.00
210702	Дотоод албан томилолт	192,000.00	416,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,175,670.49	52,314,628.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,615,570.49	45,925,425.57
210804	Тээврийн хэрэгслийн татвар	398,800.00	162,546.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500.00	5,543,500.00
210807	Газрын төлбөр	1,441,800.00	617,157.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,845,400.00	10,672,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,467,300.00	10,293,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	378,100.00	378,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,239,048.16	130,235,018.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	99,739,499.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	96,714,499.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	3,025,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	139,048.16	1,769,197.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	139,048.16	1,769,197.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,000,000.00	28,726,322.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,000,000.00	28,726,322.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	45,922,787.39	15,883,294.03
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	48,079,900.00	6,524,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,079,900.00	6,524,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,079,900.00	6,524,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	48,079,900.00	6,524,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-48,079,900.00	-6,524,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-2,157,112.61	9,359,294.03
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,197,216.09	14,040,103.48
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,040,103.48	23,399,397.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	211,741,772.61	3,080,378,360.01
2	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	211,741,772.61	3,080,378,360.01
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	211,741,772.61	3,080,378,360.01
10	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-204,038,002.97	-204,038,002.97
11	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	7,703,769.64	2,876,340,357.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,156,796,700.00	2,154,987,122.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,156,796,700.00	2,154,987,122.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,056,287,600.00	2,055,247,623.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,557,928,300.00	1,557,924,873.92
210101	Үндсэн цалин	918,201,600.00	927,476,045.35
210102	Нэмэгдэл	557,520,600.00	548,092,032.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,060,000.00	30,060,000.00
210104	Урамшуулал	51,346,100.00	51,496,796.25
210105	Гэрээт ажлын хөлс	800,000.00	800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,315,700.00	34,927,344.01
210201	Тэтгэврийн даатгал	0.00	93,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,000.00	11,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,304,700.00	34,822,844.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,587,500.00	207,564,496.61
210301	Гэрэл, цахилгаан	113,996,700.00	115,270,866.35
210302	Түлш, халаалт	91,290,800.00	89,965,630.26
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.00	2,328,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,094,100.00	40,751,348.08
210401	Бичиг хэрэг	3,800,000.00	3,854,800.00
210402	Тээвэр, шатахуун	32,532,000.00	32,532,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,335,000.00	2,937,448.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,100.00	27,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400,000.00	1,400,000.00
2105	Нормативт зардал	170,909,000.00	170,900,357.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,500,000.00	5,499,777.90
210502	Хоол, хүнс	165,409,000.00	165,400,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,544,600.00	22,537,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.00	7,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	756,900.00	756,900.00
210604	Урсгал засвар	14,287,700.00	14,280,950.00
2107	Томилолт, зочны зардал	492,000.00	416,000.00
210702	Дотоод албан томилолт	492,000.00	416,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,449,400.00	12,258,353.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,869,400.00	5,869,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	162,546.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,543,600.00	5,543,500.00
210807	Газрын төлбөр	756,400.00	617,157.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,967,000.00	7,967,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,588,900.00	7,588,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	378,100.00	378,100.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,509,100.00	99,739,499.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,509,100.00	99,739,499.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,714,500.00	96,714,499.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,794,600.00	3,025,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,156,796,700.00	2,155,000,922.52
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,121,612,800.00	2,119,857,402.52
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,121,612,800.00	2,119,857,402.52
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,183,900.00	35,143,520.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,183,900.00	35,143,520.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд 5 саяас дээш орлогын 337,491.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 28,482.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, хөрөнгө зарцуулах 2 тушаалыг тус тус мэдээлээгүй, 3 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.5, 6.4.8-т заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй мэдээллийг нөхөн оруулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Залруулсан алдаа: Аудитаар нийт 163,929.9 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангаас хүлээлгэн өгсөн 1,917.3 мянган төгрөгийн угсардаг дрожийг анхан шатны баримтад үндэслэн бүртгээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
2. Санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын дагуу бэлтгэж ирүүлээгүй, санхүүгийн тайланд тусгасан авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 8-р зүйл, санхүүгийн тайлангийн толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
3. Төлбөр тооцоог Сангийн яамны цахим системээр гүйцэтгэсэн боловч санхүүгийн баримтад 153,624.6 мянган төгрөгийн төлбөрийн хүсэлтийг хэвлэж хавсаргаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 20 дугаар зүйлийн 20.3, Засгийн газрын 2015 оны 24-р тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8 дугаар зүйлийн 8.6, санхүүгийн тайлангийн үнэн зөв илэрхийлэх, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.
4. Санхүүгийн тайланд 8,138.0 мянган төгрөгийн өвс, ноолуурын орлого зарлагыг бүртгэхдээ нярвын тайлан, анхан шатны баримтыг үндэслэхгүйгээр тусгасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3.1, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягтыг нөхөх заавар" 9. Бараа материалын тайлан, санхүүгийн тайлангийн Үнэн зөв илэрхийлэх, Зэрэгцүүлэгдэх боломжтой байх, Иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.
5. Малын тайланд 250.0 мянган төгрөгийн 1 хонийг данснаас хасахдаа эрх бүхий ажилтнуудын шийдвэр, анхан шатны баримтад үндэслээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, 14.5, санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал" Үнэн зөв илэрхийлэх, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 30,003.0 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 671.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 29,331.5 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн..

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтөд хийсэн түүвэрчилсэн тулгалтаар 21 албан хаагчид 118.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү, 36 албан хаагчид 270.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг дутуу эдлүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Илүү эдлүүлсэн хувь хүний орлогын алба татварын хөнгөлөлт 118.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, дутуу эдлүүлсэн 270.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг албан хаагчдад буцаан олгох

5.1.2 Энгийн ажилтны цалин хөлснөөс суутгах нийгмийн даатгалын шимтгэлийг ийг цэргийн албан хаагчаар тооцон суутгаснаас байгууллага цалингийн зардлаас 283.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 312.7 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 32 дугаар зүйлийн 32.2.2, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан 283.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

5.2 Албан шаардлага

5.2.1 Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж буй Киа Карнивал маркын автомашиныг бүртгэл тайланд тусгаагүй, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95-р тушаалын хавсралтаар батлагдсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.10, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж буй автомашиныг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнах

5.2.2 Бэлнээр хүлээн авсан орлогыг ажлын дараагийн өдөрт багтааж байгууллагын бүртгэлийн дансанд шилжүүлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.12 дахь заалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, кассаар хураасан орлогыг дараагийн ажлын өдөрт багтаан байгууллагын бүртгэлийн дансанд тушаах

5.2.3 Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг хүлээн авах боломжтой дүнгээр бус зөвхөн касс болон харилцах дансанд тушаасан 63,714.8 мянган төгрөгийн орлогыг бүртгэж гүйлгээг аккруэл сууриар бус мөнгөн сууриар бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.1, 14 дүгээр зүйлийн 14.4.7, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, кассаар хураасан орлогыг дараагийн ажлын өдөрт багтаан байгууллагын бүртгэлийн дансанд тушаах

5.3 Зөвлөмж

1. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт Аймгийн Засаг даргын 2022 оны А/319 тоот захирамжаар "5-8 давхар орон сууц" зориулалтаар олгосон 1500м2 газрын эзэмших эрхийг үнэлж бүртгээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх

2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.2. Илрүүлэлт Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтад үндэслэж ажил гүйлгээг бүртгэсэн. Шатахууны зарцуулалтын тооцоог батлагдсан маягтаар гаргаагүй, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан маягт зааврын НХМаягт ТМ-4 заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг таслан зогсоож, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, Сангийн сайдын баталсан маягт, заавар аргачлалын дагуу шатахууны тооцоог жолоочийн тооцооны хуудсаар хийх

3. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

1.3. Илрүүлэлт Тооллогоор 14 нэр төрлийн 4,419.0 мянган төгрөгийн бараа материал илүүдэж 698.5 мянган төгрөгийн төмс дутсан. Мөн ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг 2023 оны 01-р сараас хойш шинэчлээгүй, эд хөрөнгийг бүрэн кодлуулаагүй, албан хаагчдад картаар хүлээлгэн өгч гарын үсэг зуруулаагүй, агуулахын бүртгэл хөтлөөгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан маягт зааврын НХМаягт БМ-5, НХМаягт БМ-10, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг таслан зогсоож, 2024 оны 1-р улирлын байдлаар тооллого хийж тооллогын үр дүнгээр илүүдсэн хөрөнгийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, орлогоор бүртгэх, дутагдсан хөрөнгийг эд хариуцагчаар төлүүлж үр дүнг төрийн аудитын байгууллагад ирүүлэх

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ШШГГ-425-р хорих анги	5	163.9	3	2.2	2	161.7	5	163.9				
Дүн	5	163.9	3	2.2	2	161.7	5	163.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ШШГГ-425-р хорих анги	8	0.7	2	0.7	3	-	3	8				
Дүн	8	0.7	2	0.7	3	-	3	8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ШШГГ-425-р хорих анги	1	366.5			1	366.5		
Дүн	1	366.5			1	366.5		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ШШГГ-425-р хорих анги								
Дүн								
Нийт дүн	1	366.5			1	366.5		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			